| | | | 1.2.1 Төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 22-ны өдрийн А/603 тоот тушаалаар батлсан. Улмаар 2020 оны 1-р сарын 6-ны өдөр Төслийн Удирдах Хорооны анхдугаар хурлыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн хурлын танхимд зохион байгуулж төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэх ажлын бүрэлдэхүүн хэсгүүдэд гишүүдээс санал авч баталгаажуулсан.<br>1.2.2 Төслийн мэргэжлийн багаар гүйцэтгүүлэх судалгаа, үр дүнг боловсруулах ажил хараахан эхлээгүй байгаа боловч Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил, хүлээгдэж буй үр дүнгийн талаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон ил тод байдлын асуудлаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, семинарт оролцож тухайн төслийг хамруулсан мэдээлэл хийж төслүүдийн хэрэгжилтийн уялдаа холбоог хангах чиглэлээр санал тавьж, олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан 3 удаагийн арга хэмжээнд оролцож Монгол Улсын үндэсний илтгэлүүдийн талаар мэдээлэл хийж санал солилцсон. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах зохион байгуулалтын зохицуулалт хийгдэж байгаа болно. | | |
| | 2-р зорилтын хүрээнд: | | ***2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:*** | | |

| | | |
|---|---|---|
| 7 | **Хүрэх үр дүн 1:**<br>НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн талаарх Үндэсний дөрөвдүгээр | Бүрэлдэхүүн хэсэг 2.<br>2.1.2. • 2022 оны 04 сарын 11-13-ны өдрүүдэд ХХТ-ын шинжээчид НҮБ-ын Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засаг нийгмийн комиссын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн сургалтын төвөөс зохион байгуулсан Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдалд мэдээлэл, харилцаа холбоо технологийг ашиглах нь сэдэвт чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан.<br>Тогтвортой байдлын төлөөх орон нутгийн засаг захиргааны байгууллагын Зүүн азийн нарийн бичгийн дарга нарын газраас 2022 оны 3 сарын 16-ны өдөр зохион байгуулсан Үндэсний хүлэмжийн хийн тооллогын системийг боловсронгуй болгох болон Засгийн газар, НЗДТГ-тай хамтран хүлэмжийн хийн тооллогын системийг хэрхэн бий болгох талаарх орон нутгийн яриа хэлэлцээрт хүлэмжийн хийн тооллогын шинжээч Тэгшжаргал оролцож, Монголын хүлэмжийн хийн тооллогын систем сэдэвт илтгэл тавьсан.<br>• НҮБУАӨСК-ийн нарийн бичгийн дарга нарын газраас 2022 оны 5-р сарын 9-нөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулсан УАӨЗГХМХ-ны 2006 програм ашиглах зайн ХХТ-ийн шинжээчид хамрагдлаа. • 2022 оны 6 сарын 29-30-ны өдрүүдэд БОАЖЯ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан Уу амьсгалын өөрчлөлтийн хууль эрхзүйн талаарх сургалтад хамрагдсан.<br>2.2.1.• ХХТ-ийн баг 7-р сарын 10-13-ны хооронд цахимаар зохион байгуулагдсан Ази дахь хүлэмжийн хийн тооллогын 19 дэх удаагийн семинарт оролцлоо. Эрчим хүчний салбарын тооллогын шинжээч Б. Тэгшжаргал "Монгол Улсын хэмжээнд түлшний дэгдэмхий хийн ялгаруулалт болон бусад салбарын ялгаруулалтын хандлагуудын харьцуулалт" сэдвээр илтгэл тавин оролцсон.<br>• ХХТ-ын шинжээч Б. Тэгшжаргал 7-р сарын 26-28-ны хооронд Итали улсын Ром хотод УАӨЗГХМХ-ноос зохион байгуулсан болсон "ХХТ-ын програм хангамжийн шинэчилсэн хувилбар дээр туршилт хийн мэргэжлийн хүмүүсийн туршилтад үндэслэн санал хүсэлт авах уулзалт"-д оролцсон.<br>• ХХТ баг Ил тод байдлыг сайжруулах  нь: 6.2-р зүйлийн хүрээнд Индонезийн эдийн  засгийн асуудал хариуцсан яам (CMEA)-тай харилцан суралцах сургалтад оролцсон.  Энэхүү сургалт нь 6-р сараас 10-р сарын хооронд Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн (IGES)-ээс  зохион байгуулагдсан.<br>• АХБ-наас 9-р сарын 28-29 (Модуль1), 10-р сарын 05-06 (Модуль2), 10-р сарын 12-13 (Модуль3), 10-р сарын 19-20 (Модуль4) хооронд зохион байгуулж буй "Нүүрстөрөгчийн үнийг тогтоох бүс нутгийн сургал"-т ХХТ баг хамрагдсан.<br>•ХХТ-ийн шинжээч Ө.Даваасамбуу нь "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд дэд бүтцийн салбарт оновчтой хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь болон Төв болон Зүүн өмнөд Азийн 2030 хөтөлбөр"-ийн Олон улсын уур амьсгалын санаачилга төслийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз улсад зохион байгуулагдсан тогтвортой дэд бүтцийн талаарх мэдлэг олгох 2022 оны зуны сургалтад хамрагдсан.<br>2.4.5. • НҮБХХ болон Барилга хот байгуулалтын яамны хамтран ҮТХХ-ийн хэрэгжилтийн явцыг хэрхэн тайлагнах, барилга байгууламжаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг хэрхэн тооцох талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор 9 сарын 29-ны өдөр зохион байгуулсан ҮТХХ-ийн хэрэгжилтийг тайлагнах нь" сэдэвт сургалтад  ХХТ-ийн шинжээч Б.Тэгшжаргал "Монгол Улсын үндэсний хүлэмжийн хийн тооллого ба барилгын салбар дахь хүлэмжийн хий" сэдвээр илтгэл тавин оролцсон.<br>2.5.1. • Чанарын хяналт, Чанарын баталгаажуулалтын төлөвлөгөөг боловсруулж дууссан.<br>2.6.3. Бүх салбарын хүлэмжийн хийн тооллогын дүнг тооцож, 1990-2019 оны ерөнхий хандлагыг гаргасан. 2.6.5. • ХХҮТ-ын оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж тооллогын ажлын үйл явцын талаар санал, шүүмж авах хурлыг 2022 оны 10 дугаар саоын 28-ны өдөр зохион байгуулсан.<br>2.6.2. •Бүх салбаруудын хүлэмжийн хийн тооллогыг 2015-2019 оны байдлаар хийж гүйцэтгэсэн.<br>2.6.4. • ХХҮТ-ын тодорхойгүй байдлын дүн шинжилгээг салбар бүрт хийж гүйцэтгэсэн.<br>2.6.5. • ХХҮТ-ын оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулж тооллогын ажлын үйл явцын талаар санал, шүүмж авах хурлыг 2022 оны 10 дугаар саоын 28-ны өдөр зохион байгуулсан.<br>2.8.1. •ХХЯ-ын хандлага 1990-2019 оноор гарсан.<br>2.8.2. • ХХЯ/шингээлтийн тооцооны үр дүнд голлох ангиллын дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. |

| | | |
|---|---|---|
| | тайлан-илтгэл болон хоёр дахь хоёр жил тутмын шинэчлэгдсэн тайланг бэлтгэж конвенцын газарт өргөн барих. | Бүрэлдэхүүн хэсэг 3.<br>3.1.3. • Нийгмийн эрүүл мэнд, ядуурал, дэд бүтэц, аялал жуулчлал, хөрс, бэлчээр, ойн экосистем, амьтан, усны нөөц, мөсөн гол, мөнх цэвдэг, байгалийн гамшиг, газрын доройтол ба цөлжилт, мал аж ахуй, тариалангийн аж ахуй зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг салбаруудын өнөөгийн суурь нөхцөл, тэдгээрийн холбогдох мэдээ, статистикийг 2020 он хүртэл авч үзнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн үзүүлэлтүүдийг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цаг хугацааны цуваа, орон зайн тархалтаар харуулсан.<br>3.1.5 • Салбарын бодлогын баримт бичиг, түүний уур амьсгалын өөрчлөлттэй харилцах харилцаа, тэдгээрийн уялдаа холбоог дасан зохицох талаас нь авч үзсэн.<br>3.1.6. • Уур амьсгалын өөрчлөлтийн төсөөлөлд аль салбар илүү өртөх талаар нэгдсэн үнэлгээнд дээрх байгалийн баялаг, нийгэм эдийн засгийн салбаруудын тоон нөлөөллийн үнэлгээг ашигласан.<br>3.1.9. • Эцсийн тайлан нь өнөөгийн болон ирээдүйн цаг уурын төсөөлөл, нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, нэгдсэн үнэлгээ, дасан зохицох бодлого гэх мэт шинжлэх ухааны судалгааны бүх үр дүнг нэгтгэн монгол хэл дээр бичсэн.<br>Бүрэлдэхүүн хэсэг 4, 5.<br>4.1.6. • Хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн голлох эх үүсвэрүүдээр (1) зардлын үр ашиг болон (2) өртөг-өгөөжийн тооцоог хийх чиглэлээр олон улсад болон дотоодод хийгдсэн ажлуудыг судалж салбаруудын сааруулах арга хэмжээнүүдийн хувьд үр дүн гаргасан.<br>4.1.7. • Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай төслийн хоёр баримт бичгийг төслийн загварт нийцүүлэн салбар тус бүрээр боловсруулсан.<br>4.1.8. • Монгол хэл дээрх хувилбарыг бичсэн.<br>5.1.1. • Хоёр жил тутмын анхдугаар тайлан илтгэлд тайлагнаснаас хойш (2016-2020) шинэчлэгдсэн, шинээр батлагдсан "Алсын хараа-2050", "Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт -2019" гэх мэт улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төрөөс эрчим хүчний, уул уурхайн, аж үйлдвэрийн, ойн, ХАА-н гэх мэт бүхий л салбаруудад баримтлах бодлого, хөтөлбөрүүдэд үндэслэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах хууль, эрх зүй, бодлого, бүтэц, зохион байгуулалтын орчны талаарх мэдээллийг шинэчилсэн.<br>5.1.2. • Монгол улсын үндэсний хүлэмжийн хийн тооллогын тайланд ашиглагдсан мэдээ, мэдээллийн урсгал, хяналт тайлагналтад одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй салбар дундын хамтын ажиллагааны механизмын схемийг зураглан талуудын үүрэг оролцоог үнэлэх болон оролцооны хувь хэмжээг тодорхойлох мэдээ материалыг цуглуулан дүн шинжилгээ хийсэн. Мөн "Парисын Хэлэлцээрийг Хэрэгжүүлэх Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмрийн Зорилт -2019" баримт бичгийн зорилтын хэрэгжилтийг тайлагнах механизмтай уялдуулан салбаруудын оролцоог сайжруулах, ажлын хүрээнд тус баримт бичгийн үйл ажиллагааны хөтөлбөр болон БОАЖЯ, Голд стандарт (GOLD Standard) олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Парисын хэлэлцээрт нийцсэн ил тод байдлын тогтолцоог бүрдүүлэх нь" төслийн явцын тайлангуудтай танилцаж мэдээллийг нэгтгэн боловсруулсан.<br>5.1.3. • Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хэмжих, тайлагнах, нотлох үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх байгууллагад тавигдах шаардлагуудыг олон улсын стандарт болон 2 жил тутмын ил тод байдлын тайланг боловсруулахад тавигдах шаардлагатай уялдуулах боломжийг судалж Монгол улсад хэрэгжсэн MRV хийх чиглэлийн төслүүдийн (GOLD Standard) үр дүнд дүн шинжилгээ хийсэн.<br>5.2.1. • Нэмэлт хоёр жил тутмын тайлан-илтгэлийг олон удаа боловсруулан илгээсэн туршлагатай зарим орны хүснэгт, маягтыг судлан 2 жил тутмын ил тод байдлын тайланг боловсруулахад тавигдаж байгаа шаардлагатай уялдуулж үндэсний онцлогт тохирсон тайлагнах маягтыг шинэчлэн сайжруулах ажлыг гүйцэтгэж салбаруудын ХХЯ-г бууруулах хөтөлбөр арга хэмжээнүүдийн мэдээллийг оруулж тайлагнасан.<br>5.2.3. • Монгол улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцож буй оролцооны байдлын сүүлийн үеийн мэдээллийг нэгтгэн Парисын хэлэлцээрийн 6-р бүлгийн тусгагдсан шаардлагуудтай нийцүүлэх чиглэлийн ажлууд хийгдэж дууссан.<br>5.3.1. • Монгол улсын хүлэмжийн хийн ялгарлын хэтийн төлөвийг гаргах ажлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол улсын урт, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлого зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хэмжээ/шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хүн ам, макро эдийн засгийн |
| | **3-р зорилтын хүрээнд:** | **3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:** |
| | **Хүрэх үр дүн 1:**<br>**Дараагийн Үндэсний тайлан болон хоёр жил тутмын шинэчлэгдсэн тайланг бэлтгэхэд хамааралтай оролцогч талууд болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, зохион байгуулалтыг баталгаажуулна.** | 3-р зорилтын хүрээнд хийгдэх ажлууд нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу 2022 оны 2-р хагасаас эхлэн хэрэгжиж эхэлсэн. "Үндэсний 5 дугаар тайлан-илтгэл, Хоёр жил тутмын I болон II ил тод байдлын тайлан боловсруулах төсөл" хэрэгжүүлэх үндэслэл, бэлтгэл ажлыг орхигдуулалгүй одоогийн ажилтай зэрэгцүүлэн гүйцэтгэж эхний байдлаар санал боловсруулан хүргүүлж НҮББОХ болон Даян дэлхийн байгаль орчны илтгэлцлийн сангаас дэмжлэг авах "МАЛГАЙ ХӨТӨЛБӨР"-т багтсан 20-н орны нэг болсон. Үүний мөрөөр "Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө" (PIP)-г НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн газраас боловсруулан ирүүлснээр Монгол талаас санал, зөвлөмжийг тусган эцэслэхээр хүлээж байна.<br>3-р зорилтын хүрээнд худалдан авалтуудыг Төслийн хамтын ажиллагааны гэрээнд заасныаар Монгол улсын хууль, дүрэм журмыг мөрдөх бөгөөд үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, түүний хүрээнд худалдан авалтыг хийхдээ донор байгууллагатай зөвшилцөж хийдэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу<br>Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв дээр зохион байгуулж ажилладаг. Төслийн тайлагналыг<br>- Улирал тутмын хэрэгжилт, явцын тайлан<br>- Улирал тутмын санхүүжилтийн зарцуулалтын тайлан<br>- Хагас болон бүтэн жилийн хэрэгжилтийн тайлан (ЗГ-ын 89-р тогтоолын биелэлт)<br>- Жилийн эцсийн гүйцэтгэлийн аудит (НҮББОХ)<br>- Үндэсний аудитын газар<br>- БОАЖЯ-наас шаардах бусад тайлангууд<br>- НҮБУАӨСК-ын газраас авах судалгаа, асуумж, тайлангууд (Хагас болон бүтэн жилээр)-ыг тус тус боловсруулан хүргүүлдэг. |

| | | |
|---|---|---|
| 10 | **Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)** | **Дүгнэлт:** Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссаны дагуу 2019 оны 4-р улиралд 1-р зорилтын хүрээнд хийгдэх ажил хэрэгжиж дууссан. Төслийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлууд 2019 оны 4-р улирал, 2020 оны 1, 2-р улиралд хэрэгжсэн болно. Нийт 13 бүлэг ажил, 29 бүрэлдэхүүн хэсгийн 104 дэд ажил төслийн хүрээнд төлөвлөгдсөнөөс нийт ажлын биелэлт 2022 оны 12 дугаар сарын 8-ны байдлаар 78%-ийн биелэлттэй байна. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага болох НҮББОХ болон БОАЖЯ-аар хэлэлцэн тохирч төсөл үргэлжлэх албан ёсны хугацааг 2023 оны 6-р сар хүртэл сунгасан. Үүнтэй холбогдуулан 2 болон 3-р зорилтын хүрээнд хийгдэх бүрэлдэхүүн хэсгийн ажлуудыг 2023 оны I болон II улиралд багтаан хэрэгжүүлэхээр болсон.<br>Нийт төлөвлөгдсөн арга хэмжээг хэрэгжүүлэхэд уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжиж буй бусад төсөл хөтөлбөрүүдийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлж уялдуулах, төслийн үр дүнг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай.<br>Төслийн хугацааг 2023 оны 6 дугаар сар хүртэл нийт 10 сараар сунгах нь Конвенцын хүрээнд дараагийн төслийг цаг хугацааны завсардалгүйгээр залгуулан хэрэгжүүлэх, өмнө гарч байсан санхүүжилтийн завсардлыг багасгах боломжийн хүрээнд НҮББОХ-ийн газраас гаргасан саналын дагуу БОАЖЯ харилцан зөвшилцөж гаргасан шийдвэр юм. "Үндэсний 5 дугаар тайлан-илтгэл, Хоёр жил тутмын I болон II ил тод байдлын тайлан боловсруулах төсөл" хэрэгжүүлэх үндэслэл, бэлтгэл ажлыг орхигдуулалгүй одоогийн ажилтай зэрэгцүүлэн гүйцэтгэж эхний байдлаар санал боловсруулан хүргүүлж НҮББОХ болон Дасн дэлхийн байгаль орчны илтгэлцлийн сангаас дэмжлэг авах "МАЛГАЙ ХӨТӨЛБӨР"-т багтсан 20-н орны нэг болсон. Ингэснээр Энэ ажилд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн газраас байнгын хамтын ажиллагаа, дэмжлэгтэй явж байгаа тул хугацааны хувьд 2023 оны 6-р сар хүртэл нийт 10 сараар сунгасан нь дараагийн төслийг залгуулан хэрэгжүүлэх, төсөл хоорондын албан ёсны хэрэгжих хугацаанд зай үүсгэхгүйн тулд дээрх шийдвэр гарсан гэж үзнэ. Монгол улсаас өргөн барьж байсан Конвенцын Үндэсний тайлангуудын цаг хугацааны ялгаа, зөрүүг харьцуулан үзвэл<br>- Үндэсний 1 дүгээр тайлан 2001 он<br>- Үндэсний 2 дугаар тайлан 2010 онд<br>- Үндэсний 3 дугаар тайлан 2018 онд зэргээр өргөн барьсан байдаг.<br>- Үндэсний 4-р тайлан, 2 жил тутмын II тайланг 2022 онд эхний төслийг бэлэн болгож 2023 онд эцсийн хяналтыг оруулан өргөн барих<br>- Үндэсний 5 дугаар тайлан-илтгэл, 2 жил тутмын I болон II ил тод байдлын тайлан боловсруулах төсөл"-ийг 2023-2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.<br>Үүнээс дүгнэн үзвэл төсвөөс энэ процесст тусгайлан анхаарч дэмжлэг үзүүлдэггүй, харин гадаадын тусламжийг хүлээн авах хүчин чармайлтыг дээрх тайлан илтгэлүүдийн үр дүнд үндэслэн дараагийн тайланг боловсруулах ажлын үндэслэл үүсэж санхүүжилт хүлээн авч боловсруулдаг. Нийт хүлээлгэн өгсөн тайлангуудын мөчлөгөөс харвал 8-10 жилийн зайтай өргөн барьж байсан нь санхүүжилтийн завсардал, хоцрогдол үүсэх нөхцөл тухайн үед байсан, харин сүүлийн жилүүдэд тайлан боловсруулах баг санхүүжилтийг богино хугацаанд залгуулан хүлээн авахад анхааран ажиллаж байгааг харуулж байна.<br>УАНС, НҮББОХ, НҮБХХ-ийн газар, АХБ, ДБ зэрэг олон улсын байгууллага, санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлж байсан төслүүд цар тахлын хугацаанд хэрэгжилтийн хугацаан албан ёсоор 6-12 сараар сунгаж байсан. Харин энэ хугацаанд манай төслийн үйл ажиллагаа нь бусад төслүүдтэй харьцуулахад гацаж саатах, төслийн нэгж чадамжгүй болох, мөнгө санхүүгээ татан авч чадахгүй гэх зэрэг асуудлууд үүсээгүйн дээр харин төслийн багийн гишүүд бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, удирдлага солигдох зэрэг тогтворгүй байдал үүсэх бүрд 2014 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй, тогтвортой, үндсэн зөвлөх багуудтай эргэх холбоотой ажиллаж ирсэн. Мөн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орох, түүнтэй холбогдон төслийн санхүүжилт орж ирэхэд хэд хэдэн гацаа үүсэж байсанд төслийн баг цаг тухайд ажиллаж шийдвэрлүүлж ажилласан.<br>94,666 ам.доллар - Гүйцэтгэгч байгууллага буюу БОАЖЯ-наас гаргах мөнгөн бус хувь нэмэр: Аливаа гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн гэрээ, хэлэлцээрт заасан санхүүжилтийн хувийг талууд хариуцан гэрээний заалтын дагуу гаргаж үүргэ гүйцэтгэх үүрэгтэй. Энэ ухагцаанд НҮББОХ болон ДДБОИС-гаас төслийн санхүүжилт, зарцуулалт, хэрэгжилтэд давхар хяналт тавьж улирал тутамд илгээсэн тайлан, санхүүгийн зузаатгалын хүсэлтэд үндэслэн төслийн санхүүжилтийг цаг тухайд нь олгож байсан. Харин 94,666 ам.доллартай дүйцэхүйц гүйцэтгэгч байгууллага буюу БОАЖЯ-наас гаргах мөнгөн бус хувь нэмрийг төслийн нэгжийн ажиллах албан байр сууж, нөхцөлөөр хангах асуудлыг анхааралдаа авах шаардлагатай. |
| | **Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ** | |

| **Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)** | **Биелэлтийн дундаж** | **Зорилт 1** | **Зорилт 2** | **Зорилт 3** | |
|---|---|---|---|---|---|
| | 78% | 100% | 90% | 43% | |

**Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт**

( 2022 оны жилийн эцсийн байдлаар )

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | | Гүйцэтгэл | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).** | | "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх" | | |
| 2 | **Төсөл, хөтөлбөрийн зорилго** | | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгоход оролцогч талуудын институцийн болон техникийн чадавхыг үндэсний ба орон нутгийн хэмжээнд бэхжүүлэхэд төслийн зорилго оршино. | | |
| 3 | **Санхүүжилтийн эх үүсвэр** | | Уур амьсгалын ногоон сан<br>Буцалтгүй тусламж | | |
| 4 | **Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа** | | **Гүйцэтгэгч байгууллага**: БОАЖЯ<br>**Дамжуулан хэрэгжүүлэгч байгууллага:** НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр | | |
| | | | 2019/08/20-2023/06/17 | | |
| 5 | **Төсөл, хөтөлбөрийн зорилтууд** | | 1. Үндэсний дасан зохицох төлөвлөлттэй (ҮДЗТ) холбоотой арга хэмжээг боловсронгуй болгоход гол оролцогч талуудын институцийн болон техникийн чадавхыг сайжруулах | | |
| | | | 2. Найдвартай, тогтвортой үйл ажиллагаа бүхий уур амьсгалын үйлчилгээний систем болон өртөг-өгөөжийн дүн шинжилгээ хийх тогтолцоо болон дасан зохицох нэн тэргүүний хувилбаруудын үнэлгээг бий болгох | | |
| | | | 3. Монгол Улсад ҮДЗТ-ийн процессыг тогтвортой хэрэгжүүлэх санхүүгийн хэрэгцээ, эх үүсвэр,стратегийг боловсруулах | | |
| | | | 4. ҮДЗТ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог загварчлан боловсруулах, ҮДЗТ-ний боловсруулалт, хэрэгжилтийг сурталчлах, Монгол улсад ҮДЗТ-ийн үйл явцаас суралцах үүднээс холбогдох баримт бичгийг боловсруулах | | |
| 6 | **Зардал** | **Төсөв (нийт шаардагдах зардал)** | 2.8 сая ам. доллар | | |
| | | **Үүнд:** | **Төсөв (он)** | **Гүйцэтгэл** | **Хувь** |
| | | **Багц №** | 2020 | 497,622.07 | 33.30% |
| | | **Багц №** | 2021 | 355,560.34 | 32.00% |
| | | **Багц №** | 12/7/2022 | 468,270.00 | 49.00% |
| 7 | **Төсөл, хөтөлбөрийн зорилт:** | | **Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.** | | |
| | ***1.1-р зорилтын хүрээнд ҮДЗТ-г боловсруулж, хэрэгжүүлэх суурийг тавих, шаардлагатай суурь судалгааг хийсэн байна.*** | | | | |
| 1 | **Хүрэх үр дүн 1: (1.1.1; 1.1.2; 1.1.5)** | | 1.ҮДЗТ-ийг боловсруулах, хэрэгжүүлэх процессыг тодорхойлсон протокол эцэслэн англи, монгол хэл дээр хэвлэгдсэн | | |
| 2 | | | 2. ҮДЗТ-ийг хэрэгжүүлэх арга замын стратегийн зураглалыг эцэслэн англи, монгол хэл дээр хэвлэгдсэн | | |
| 3 | | | 3. ҮДЗТ-ийг бий болгох, хэрэгжүүлэх процессын удирдамжийг эцэслэн англи, монгол хэл дээр хэвлэгдсэн | | |
| 4 | | | 4. Тус ажлын хүрээнд боловсруулсан мэдээллийг нэгтгэн олон нийтэд танилцуулах 3 сургалтын тараах материалыг англи, монгол хэл дээр хэвлүүлсэн. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://ndc.mne.gov.mn/public/storage/e-resources/December2021/8FDZgnKSpLjtjwqEQPrn.pdf | | |
| 5 | | | 5. Орон нутгийн болон оролцогч талуудад 4 удаагийн хурлыг зохион байгуулсан. | | |
| 6 | | | 6.Орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл бүхий 3 өдрийн сургалт семинарыг зохион байгуулсан. 21 аймгийн 80 хүн, нийтдээ 126 хүн оролцлоосон. | | |
| 7 | | | 7. Оролцогч талуудтай судалгааны үр дүнг бататгах хурлыг зохион байгуулсан. | | |
| 8 | | | 1.Судалгааны арга зүйн зөвлөлдөх хурлыг зохион байгуулсан | | |
| 9 | | | 2. Судалгааны үр дүнг бататгах хурлыг зохион байгуулсан. | | |
| 10 | | | 3. УАӨ-ийн нөлөөллийн талаарх судалгааг нэгтгэн үнэлсэн үнэлгээний тйаланг төлөөлөл болгон 3 салбарын хувьд (Иргэдийн амжиргаа, эрүүл мэнд, БОЯБ) боловсруулсан. | | |

| | | |
|---|---|---|
| 11 | **Хүрэх үр дүн 2: (1.1.3)** | 4.УАӨ-д дасан зохицох стратегийг үнэлсэн үнэлгээний 3 (Иргэдийн амжиргаа, эрүүл мэнд, БОЯБ) тайланг боловсруулсан. |
| 12 | | 5. УАӨ-ийн нөлөөллийн үнэлгээг хийх арга зүйг тайлбарласан гарын авлагыг англи, монгол хэл дээр боловсруулж хэвлэсэн. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://ndc.mne.gov.mn/public/storage/e-resources/December2021/kN8vPbADCAz41OkF9L9Z.pdf |
| 13 | | 6.УАНС-д Монгол Улсаас хүргүүлэх зөвлөмжийг боловсруулан тайланг тусгасан. |
| 14 | **Хүрэх үр дүн 3: (1.1.4)** | 1. Судалгааны арга зүйг хэлэлцүүлэх зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан |
| 15 | | 2.Жендерийн ялгаатай байдлын үнэлгээний чиглэлээр орчин үеийн судалгаа шинжилгээний материалуудтай танилцаж судлагдсан байдлын тайланг боловсруулсан. |
| 16 | | 3.Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх 2 удаагийн хурлыг зохион байгуулсан. |
| 17 | | 4. Судалгааны үр дүнг батлагтах хурлыг зохион байгуулсан. |
| 18 | | 5. Жендерийн ялгаатай байдлын үнэлгээни эцсийн тайланг монгол англи хэл дээр боловсруулсан. |
| 19 | | 6. Судалгааны гарын авлагыг англи монгол хэл дээр боловсруулсан. chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://ndc.mne.gov.mn/public/storage/e-resources/December2021/PiakpOb58kiNBJrESWkR.pdf |
| ***1.2-р зорилтын хүрээнд УАӨ-д Дасан зохицох хувилбаруудыг нэгтгэх, дасан зохицох төлөвлөлтийг хийх нэгдсэн арга зүйг боловсруулж сурталчилсан байна.*** | | |
| 1 | **Хүрэх үр дүн 1: (1.2.1-1.2.3)** | 1.УАӨ-ийн сөрөг нөлөөллийг даван туулах орон нутгийн онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, Дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийж, үндэсний хэмжээнд УАӨ-д ДЗ тэргүүлэх чиглэл/салбарууд, газарзүйн байршлыг тодорхойлох судалгааны тайланг боловсруулсан. |
| 2 | | 2. Судалгааны арга зүйн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. |
| 3 | | 3. Техникийн зөвлөлдөх хурлыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнг батлагтах хурлыг 2022 оны 4 сарын 07-нд зохион байгуулсан ба 21 аймгийн 5 төрийн байгууллагын төлөөлөл бүхий 100 гаруй мэргэжилтнүүд оролцсон. |
| 4 | | 4. Судалгааны үр дүн, арга зүй бүхий гарын авлагын боловсруулсан. |
| 5 | **Хүрэх үр дүн 2: (1.2.5)** | 1."Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын дасан зохицох үйл ажиллагааны зорилтуудын суурь болон хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлын үр дүнгийн батлагтах хурлыг зохион байгуулсан. |
| 6 | | 2. Дээрх судалгаанд шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулах зорилгоор салбар дундын хэлэлцүүлгийг 7 удаа зохион байгуулсан. |
| 7 | | 3. "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын дасан зохицох үйл ажиллагааны зорилтуудын суурь болон хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох ажлын тайлан англи монгол хэл дээр боловсруулсан. |
| 8 | **Хүрэх үр дүн 3: (1.2.5)** | 4. ҮДЗТ-ийн цахим платформыг бий болгож хүлээлгэн өгөөд байгаа ба, цаашид тус платформын тогтвортой үйл ажиллагааг БОАЖЯ-ны УАӨГ хариуцан ажиллахаар боллоо. (https://ndc.mne.gov.mn/actions/mn) |
| 9 | | 5. Тус платформыг хүлээлгэн өгөх, батлагтах хурлыг зохион байгуулсан. |
| ***1.3-р зорилтын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох эрх зүйн орчинг бэхжүүлсэн байна.*** | | |
| 1 | **Хүрэх үр дүн 3: (1.3.1-1.3.4)** | 1. Хууль эрхзүйн судалгааны тойм тайлангболовсруулсан. |
| 2 | | 2.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хууль эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгох дэлгэрэнгүй тайланг боловсруулсан. |
| 3 | | 3."Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөр, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хууль эрх зүйн орчны үнэлгээ"-ний тайланг боловсруулаад байна. |
| 4 | | 4. зорилтот оролцогч талуудтай хийх 1 удаагийн семинар зохион байгуулахаар төлөвлөж байна. |
| 5 | | 5.Институци, эрх зүйн шинжээчид, хуулийн мэргэжилтнүүдийг хамруулсан өндөр түвшний уулзалтыг зохион байгуулна. |
| 6 | | 6. шинэчлэлийн стратегийн үндэсний хэмжээний семинарын тайланг боловсруулна. |
| ***2.1-р зорилтын хүрээнд Тогтвортой ажиллах уур амьсгалын үйлчилгээний системийг бий болгосон байна.*** | | |
| 1 | **Хүрэх үр дүн 1: (2.1.1)** | 1.Үнэлгээ зөрүүтэй байдлын тайланг монгол англи хэл дээр боловсруулсан |
| 2 | | 2. "Уур амьсгалын үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох" чиглэлээр хэлэлцүүлгийг орон нутагт 3 удаа зохион байгуулсан. |
| 3 | | 3. Уур амьсгалын мэдээллийн системийг бий болгох ажлын хүрээнд мэргэжилтэн албан хаагчдыг хамарсан зөвлөлдөх хурлыг зохион байгуулсан. |
| 4 | | 4. Уур амьсгалын үйлчилгээний системийн анхны хувилбарыг танилцуулах хурлыг зохион байгуулсан. |

| | | |
|---|---|---|
| 5 | Хүрэх үр дүн 2: (2.1.2) | 1. Цаг агаарын урьдчилан мэдээлэх үйлчилгээний системийг дэмжих серверийн компьютерууд болон хадгалах системийг худалдан авах зөвшөөрлийг НОББОХ-с авсан. |
| 6 | | 2. Тоног төхөөрөмжийн суурилуулалт, техникийн үзлэг болон хүлээн авсан тухай тайланг монгол хэлээ боловсруулсан. |
| 7 | | 3. УЦУОШСХ-ийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. |
| 8 | Хүрэх үр дүн 3: (2.1.3) | 1. Боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлэг хурлыг зохион байгуулсан. |
| 9 | | 2. Уур амьсгалын үйлчилгээний системийг боловсруулах, цаг уурын тоног төхөөрөмжийг ашиглах талаарх сургалтыг зохион байгуулсан. |
| 10 | | 3. уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийн хувилбар, загварыг боловсруулж, жишээнүүдээ сервер дээрээ тавьж платформ байгуулсан.(http://119.40.97.103/climateservice/) |
| 11 | Хүрэх үр дүн 4 : (2.1.4) | 1.Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн сценарийг шинэчлэн тооцоолсон үр дүнгийн тайлан боловсруулсан. |
| 12 | | 2. Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн сценарийг дэлхийн уур амьсгалын загварын Үнэлгээний 6-р илтгэлийн үр дүнгээр шинэчлэн тооцоолж, авсан мэдээ, мэдээллийг татав. Монгол улсын газар нутгийн хувьд орон зайн нарийвчлалыг сайжруулах ажлыг хийж дууссан. |
| 13 | | 3.“Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн сценарийг шинэчлэн тооцоолсон үр дүн”-гийн тайланг боловсруулсан. |
| 14 | | 4. Техникийн шинжээчдийн 2 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. |
| 15 | Хүрэх үр дүн 5 : (2.1.5) | 1. Уур амьсгалын мэдээллийн системийг сайжруулах, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх тайланг боловсруулсан. |
| 16 | | 2. Уур амьсгалын үйлчилгээний системийг бий болгох ажлын үр дүнг бататгах хурлыг зохион байгуулсан ба тус хуралд тус системийг хэрэглэгч төрийн байгууллагын төлөөлөл бүхий 73 хүмүүс оролцлоо. (http://119.40.97.103/climateservice/) |
| 17 | | 3.“Уур амьсгалын үйлчилгээний системийн хэрэглэгээ, ашиглалт” сэдвээр төв, зүүн, баруун, хангай, говийн зэрэг 5 бүсүүдээр орон нутгийн оролцогч талуудын хурлыг зохион байгуулсан.. |
| 18 | | 4. Уур амьсгалын үйлчилгээний системийн ашиглалтын гарын авлагыг боловсруулсан. |
| ***2.2-р зорилтын хүрээнд Дасан зохицох арга хэмжээг үнэлэх, өртөг-өгөөжийн дүн шинжилгээ хийх тогтолцоог бий болгосон байна.*** | | |
